



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/300

Мандалговь

Баяр наадам тэмдэглэн өнгөрүүлэх
тов тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4, нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 сарын 08-ны өдрийн 222 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол Улсын 815, 816, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Дундговь аймаг байгуулагдсаны 80 жилийн ой, Сайнцагаан сумын 98 жилийн ойн баяр наадмыг 2022 оны 07 дугаар сарын 29,30-ны өдрүүдэд тус тус тэмдэглэн өнгөрүүлэхээр тогтоосугай.

2. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн дагуу аймгийн баяр наадмыг тогтоосон хугацаанд зохион байгуулахыг аймгийн баяр наадмыг зохион байгуулах комиссын дарга, салбар комиссын дарга, гишүүдэд тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111053